



2017 оны 02 дугаар сарын 22-ны өдөр

Улаанбаатар хот

**ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ  
ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ЭЗЭМШИГЧ АЖ АХУЙ НЭГЖҮҮДЭД  
ҮЗҮҮЛЭХ ЗӨВЛӨН ТУСЛАХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР**

Нэг. Зорилго:

Нийслэлийн мэргэжлийн хяналтын байгууллагын 2017 оны хяналт шалгалтын төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу геодези, зураг зүйн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаанд "Геодези, зураг зүйн тухай", "Кадастрын зураглал ба газрын кадастрын тухай" хуулиуд болон бусад холбогдох хууль тогтоомж, стандарт, дүрэм журмын мөрдөлтийн байдалд хяналт тавьж, хэрэгжилтийг хангуулах, илэрсэн зөрчил, дутагдлыг арилгуулж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, үнэлгээ дүгнэлт гаргах замаар эрсдлийг бууруулах арга хэмжээ авахад оршино.

Хоёр. Зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх бүрэлдэхүүн, хугацаа:

Байгаль орчин, газар, геодези, зураг зүйн хяналтын улсын ахлах байцаагч Я Жамъян, байгаль орчин, газар, геодези, зураг зүйн хяналтын улсын байцаагч С Болорцэцэг нарын бүрэлдэхүүнтэйгээр хийж гүйцэтгэнэ.

Гурав. Хамрагдах аж ахуйн нэгжийн нэр:

Геодези, зураг зүйн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч 20 аж ахуйн нэгжүүд хамрагдана. Үүнд:

1. Пүга мэл ХХК, 2. Майнсио ХХК, 3. ТМ инженер ХХК, 4. Зэвт-Уул ХХК, 5. Голден мэл ХХК, 6. Ордгесд ХХК, 7. Кеестон сүрээй ХХК, 8. Грандбридж ХХК, 9. Хүрэнтолгод ХХК, 10. Титэмгазар ХХК, 11. Гео-Экспресс ХХК, 12. Мэлдизайн атлас ХХК, 13. Монголзүрх сэтгэл ХХК, 14. М Си Эс Проперти ХХК, 15. Мастер пойнт ХХК, 16. Мандахтөр ком ХХК, 17. Соолонсанчир ХХК, 18. Борголжин-Эрдэнэ ХХК, 19. Жейлбаян богд ХХК, 20. Бэйспойнт ХХК-иуд

Дөрөв. Гүйцэтгэх ажил.

Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын даргын 2017 онд батлагдсан 2.18 дугаартай "Геодези, зураг зүйн үйл ажиллагааг шалгах хяналтын хуудас"-ыг ашиглан аж ахуйн нэгж бүрийн үнэлгээг тодорхойлно.

Хамрагдсан аж ахуйн нэгжүүдэд эрсдэлийг бууруулах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, дотоод хяналтыг зохион байгуулах талаар зөвлөгөө өгнө.

Тав. Эхлэх болон дуусах хугацаа:

Зөвлөн туслах үйлчилгээг 2017 оны 03 дугаар сарын 02-ны өдрөөс эхлэн 04 дүгээр сарын 30-ны өдрийг дуустал хийж гүйцэтгэнэ.

Зургаа. Үр дүн.


1. Зөвлөн туслах үйлчилгээний үр дүнг нэгтгэн, хамрагдсан байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтанд танилцуулж, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах арга хэмжээ авч, эрсдэлээс урьдчилан сэргийлэх талаар мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, зөвлөмж хүргүүлэн ажиллана.

2. Дүнгийн нэгдсэн танилцуулга, дүгнэлт, холбогдох бусад мэдээллийг хавсралтын хамт гаргаж, тогтоосон хугацаанд МХЕГ болон холбогдох байгууллагуудад ажлын 10 хоногт багтаан хүргүүлнэ.

ТАНИЛЦСАН:  
ДЭД ДАРГА

  
С.ДАВААСҮРЭН

ХЯНАСАН:  
БАЙГАЛЬ ОРЧИН, ГЕОЛОГИ,  
УУЛ УУРХАЙН ХЯНАЛТЫН  
ХЭЛТСИЙН ДАРГА

  
Д.БАТ-ӨЛЗИЙ

БОЛОВСРУУЛСАН:  
БАЙГАЛЬ ОРЧИН, ГАЗАР,  
ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ХЯНАЛТЫН  
УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧ

  
Я.ЖАМЪЯН

БАЙГАЛЬ ОРЧИН, ГАЗАР,  
ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ХЯНАЛТЫН  
УЛСЫН БАЙЦААГЧ

  
С.БОЛОРЦЭЦЭГ